

Жамбын ДАШДОНДОГ



ДОЛООН
БӨХТЭЙ
ТЭМЭЭ





Жамбын ДАШДОНДОГ


Долоон бөхтэй
ТЭМЭЭ

Улаанбаатар 2007




I

Энэ бол Монголын их говь. Эргэн тойрон элсэн манхан. Тээр тэнд ганц айл харагдаж байгаа биз? Заримдаа зэрэглээнд олон давхар ч юм шиг үзэгддэг. Тэр бол манайх.



2


Энэ бол миний ботго.
“Том болоод унаарай” гэж
аав надад зүслэж өгсөн
юм. Тэгээд бас “Элсэн
далайн хөлөг онгоц чамайг
газардуулахгүй” гэж
хэлсэн. Би үлгэрийн оронд
очиж үзэхсэн гэж дандаа
мөрөөддөг. Гэхдээ хаана
байдгийг нь мэдэхгүй л дээ.






3

Нэгөдөр бороо орлоо. Норсон гэрийг түмэн дуслаараа бөмбөрдөөд л. Ногоо суга ургана гэж аав, ээж баярлаад л. Харин надад бол гэрт хашигдан суух нь уйтгартай. “Хувцсаа норгоно” гээд ээж гаргахгүй юм чинь.










4

Аав сур нухаж, ээж тохош
оёно. Ах буйл зорж, эгч
бурантаг томно. Дүү унтаад
өгчээ. Энэ удаад ээж биш
бороо бүүвэйлсэн бололтой.
Манайх гэж ийм л айл. Дор
дороо л ажилтай. Би юу хийе
дээ, байз. Зураг зурдаг юм
бил үү? Нээрэн тэгье.

5

Яг одоо би үлгэрийн орон луу тэмээгээр явах гэж байна. Их л хол байдаг байх даа. Гэсэн ч миний тэмээ хүргээд өгчих юм чинь. Хаашаа явах вэ? Тэмээ маань эхлээд үлгэрийн орныг олж хараг. Тэгэхээр хүзүү нь урт байж таарна. Уулнаас дээш, бүр үүлнээс дээш. Арай хэтэрчихэв үү? Гайгүй ээ. Алсын орныг тэр олж харлаа. Тийшээ явъя.



6

За явъя байз! Ганцаараа
явбал аав ээж араас зовно.
Хамт явъя гэхээр бөх
дутаад байдаг. Яадаг юм
бэ, нэмээд зурчихая. Ер
нь манайхан бүгдээрээ л
үлгэрийн орныг үзэг. Ахад
нэг, эгчид нэг... Хөөх, яасан
олон бөх болчихов оо? Өө
дүү үлдчихэж. Бас нэг бөх.
Нэмж зурсаар байтал тэмээ
маань бүр долоон бөхтэй
болчихлоо. Ямар гоё вэ?
Хөөг! Хөөг!





7

Үлгэрийн оронд бушуухан л хүрэх юмсан. Яарч байхад тэмээний алхаа нэг л удаан санагдаад болдоггүй шүү. Ерөөсөө л хурдан морины хөл зурчихая. Зурсаар байтал зөндөө хөл. Арай олон болчихов уу? За яахав, хөл нэмэгдэх тусам хурд нэмэгдэх биз. Тийм ээ? Одоо ч хурдлаад байна даа. Чүү!





8


Араасхөх чоно! Ий! Араа шүд нь арзайгаад аймаар байгаа биз. Нэг, хоёр, гурав ... Пөөх ямар олон чоно вэ? Өө, айх юу байхав. Тэмээндээ эвэр зурчихая. Урьд цагт буганд хууртаад эврээ алдчихсан юм гэдэг. Одоо эвэртэй болсон хойно, муусайн чононуудыг түс түс хийтэл мөргөөд л, ай ёстой мундаг аа!






9


Одоо ч айх юу байх вэ?
Пээ, яана аа! Өмнө талд
нэлийсэн цагаан далай!
Ёстой л туурт морь туулж
гарамгүй тураг шувуу нисч
барамгүй их ус! Бодно оо, хө.
Өө ингэе. Тэмээндээ сэлүүр
зураад л гүйцээ. Загас шиг
сэлээд л гарчихна биз. Тэгнэ
ээ, тэр. Яг л санаснаар минь
боллоо.





10

Усан замыг саадгүй туулаад цаашилтал нэвтрэх аргагүй ширэнгэн ой таарлаа. Тэмээ нь байтугай сүүл нь ч шургах янз алга. Ямар ч гэсэн нэг ухаан сийлнэ дээ. Тэгсэн чинь миний гар тэмээг яах ийхийн зуургүй далавчтай болгоотхов. Ай, дэвээд бай, дээшлээд бай! Уухай, нисчихлээ.





11

Нэг мэдэхнээ дуниартсан их хөвч шувтрав бололтой. Тэмээ маань доошлон доошилсоор алгуурхан буулаа. Тэгсэн чинь үүлс нүүх цэнхэр алст юу харагдсан гэнэ. Өнгө өнгөөр солонгорсон нэг их гоё хот! Нөгөө үлгэрийн орон гэдэг нь тэр байлгүй. Бид тийшээ гүйлдэв. Хариугүй хүрдэгийн даваандээр “Тэнгэр онгойлоо” гэсэн үг сонсогддог байна шүү! Би ч зургаа орхиод гүйн гарлаа.





12

Ямар гоё гээч! Долоон өнгийн саатай торгоор хийсэн бөмбөгөр өргөө бий болчихжээ. Тэр өргөө түм буман алтан баганан дээр тогтон байх шиг. Энд тэндгүй л есөн эрдэнэсээр урласан юм шиг цэцэгс. Их хуурын эгшгээр ингэ гунганахад, түүний аялгуунд ботго нь тойрч бүжнэ. Хөл нүцгэн гүйлдэхэд газар нь үүл дэвсчихсэн мэт зөөлхөн. Ай, жинхэнэ үлгэрийн орон гэгч энэ байжээ.






13


Солонгон өргөө замхран
замхарсаар алга болов.
Гэсэн ч түүний шидэт долоон
өнгө говь нутагт минь шингэн
үлдлээ. Нарны түмэн цацрал
алтан толгодод уусав.
Тийнхүү говь үлгэрийн орон
чигээрээ үлдлээ.







14



Үлгэрийн оронд хүргэж өгсөн долоон бөхтэй тэмээгээ гэнэт санаж гэртээ гүйн ортол ... Хүүе, аав яаж байгаа юм бэ? Миний тэмээг балруулдаад оронд нь нэг том ат зурчихаж.

“Ийм тэмээ байдаггүй юм. Хүн үзвэл миний хүүг мал мэдэхгүй гэж шоолно. Тэмээг ингэж зурдаг юм шүү дээ!” Аав ингэж хэлээд зурсан зургаа надад өглөө.

15

Миний ботго үнэхээр аавын зурсан шиг томоо сайхан тэмээ болно. Түүний эзэн болох хувь ч надад бий. Тэгээд солонго татсан говьдоо өнө удаан амар амгалан аж төрнө. Гэсэн ч би долоон бөхтэй тэмээгээ мартаж чадахгүй нь. Яагаад гэвэл намайг үлгэрийн сайхан оронд хүргэж өгсөн юм шүү дээ!







Тээр жил Өмнеговь аймгийн Номгон сумаар аялж яваад элсэн манхан дундах ганц айлд буувал хөдөлмөрийн баатар Гомбосүрэн гуайнх байв. Баатар зүгээр сууна гэдгийг үл мэдэх нэгэн байлаа. Ажлаа зэрэг зэрэг амжуулах нь сонин. Надтай ярихдаа ч сур нухаж л сууна. Ач зээ нар нь өвөө шигээ ажилсаг. Тэдний нэг нь малд явахаар тэмээгээ сөгдүүлтэл бүгд л би явна би явна болоотхов. Тэгтэл мань баатар үл мэдэг жуумалзсанаа "Наадах чинь та нарыг багтаах тийм олон бөхтэй юм биш байгаа биз дээ" гэтэл бүгд инээлдэж билээ. Түүнээс хойш баатрын үгийг бодсоор явтал нэг мэдэхнээ шинэ номын минь хуудсан дээр долоон бөхтэй тэмээ амилсан нь энэ билээ.

Зохиогч

Ж.Дашдондог

Долоон бөхтэй тэмээ

2 дахь удаагийн хэвлэл

Сургуулийн өмнөх насныханд

Номын зургийг зохиогч урлав.

Хянан тохиолдуулагч О.Мөнхтуяа
Хэвлэлийн эх бэлтгэсэн Д.Хишигдэлгэр
Хянагч Ж.Гэрэлмаа



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он



Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.